



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/380

Чингис хот


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30.3.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах болон сумдын бүтээн байгуулалтын ажилд тухайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж байгаа эсэхэд хяналт тавих үйл ажиллагаанд зориулж 1.880.000 (нэг сая найман зуун наян мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Г.Лхагвахатан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ЦИДЭРБАТ



231011877

Аймгийн Засаг даргын 2021 оны
08 дугаар сарын 17 өдрийн 1/380
дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Туулах зам	Шатахуун	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Бензиний зардал /урд бүс/	1195км	250л	2150	537.500
2	Бензиний зардал /хойд бүс/	865км	250л	2150	537.500
3	Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх гарын авлага, брошур, тараах материал	230ш	-	3500	805.000
Нийт					1.880.000